

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Аудитор: О.Баярсайхан

Аудитор: Г.Үүрийнтуяа

Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2025.05.28

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ГНАГ-2025/06-02-ШТА-НА	Шалгагдсан байгууллага, нэгжийн	АЗДТГ, ХБТХОХ, ХААГ, ГХБХБГ, Төрийн байгууллагууд
Аудитын нэр:	“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Гүйцэтгэл, нийцлийн аудитын баг

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитыг Дундговь аймагт 2024 онд орон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд үндэслэн хийсэн.

2.2 Бүлэг А. Аудитын дүн:

А. Гол асуулт / аудитын дэд зорилт 1: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

- **Хариулт:** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хууль, журамд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 удаа төсөвт тодотгол хийсэн бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 26,366.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 22,471.9 сая төгрөгийн

санхүүжих дүнтэй 86 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болгож баталсан байна. Энэ нь тус онд санхүүжих хөрөнгө оруулалтыг анхны батлагдсан төсвөөс 16,068.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.

Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 17.0 хувь буюу 3,810.1 сая төгрөгийг төсөл хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 2,627.3 сая төгрөг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, сүү хөтөлбөр, тэмцээн уралдаан, наадам зохион байгуулах зэрэг хөрөнгийн бус нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд хөрөнгө оруулалтын зардлыг зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹-д заасныг зөрчиж байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж батлахдаа хөрөнгийн бус шинж чанартай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр батлахгүй байх нь зүйтэй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй хэрхэн уялдуулж төлөвлөсөн байдлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт-1: Төлөвлөсөн ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Төлөвлөсөн ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	Нийцсэн			Нийцээгүй		
	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн	Хувь
"Аймаг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл"	74	28,668.0	86.1	12	698.6	13.9
"Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"	78	28,812.9	90.7	8	553.7	9.3

Төлөвлөсөн ТАХ-ний 698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ нь "Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл"-тэй, 553.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ нь "Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй тус тус уялдаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4²-д заасныг зөрчиж байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөөгүй зөрчил таван жилийн үндсэн чиглэлтэй уялдаагүй зөрчил буурсан бол Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй зөрчил өмнөх оноос 6.4 хувиар өссөн байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байгааг харуулж байна. Иймд зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Хүснэгт- 2. Хөтөлбөр болон өмнөх оноос шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээг оруулаагүй болно.

ТАХ-ний ангилал	Төлөвлөсөн ТАХ-ний тоо	Зураг төсөв, ТЭЗҮ-тэй эсэх		Ерөнхий магадлал болон эрх бүхий этгээдээр хянагдсан эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Барилга, байгууламж	33	29	4	9	24
Тоног төхөөрөмж	27	25	2	0	27
Их засвар	10	10	0	4	6
Дүн	70	64	6	13	57

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн төслийн саналд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагад үндэслэн, нэн тэргүүний чухал ач холбогдолтой төслүүдийг тодорхойлон эрэмбэлж, жагсаалт гарган баримтжуулахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29¹.1³ дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁴, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар

¹ “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

² Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах зарчмыг баримталж холбогдох тайлан материалыг хавсарна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
- Хэрэгцээ шаардлага үндэслэл;
- Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл;

³ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна;

⁴ Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 2.2.2⁵ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн аймгийн урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ирээдүйд үр өгөөжөө өгөх, орон нутгийн хөгжилд тодорхой дэмжлэг болохуйц хөрөнгийн шинж чанартай төсөл, арга хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад “Дашгэнпиллэн хийдийн барилгын дотор завсар”, “Нийтийн эзэмшлийн орон сууцуудын давхар дундын цахилгааны шийт солих”, “Гэр” төсөл, Мандалговь хотын сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх байр, зэрэг 630.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2⁶ дахь заалтыг зөрчиж тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэх боломжгүй хөрөнгө бэлтгэхээр төлөвлөсөн байна.

Сайнцагаан сумын Айраг, Арвижих багуудад ахмадын төв шинээр барих, Олгойн говийн ус цэвэршүүлэх байгууламжийн барилга шинээр барих, Дэлгэрхангай сумын 4 дүгээр багийн төвийн барилга шинээр барих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө үндсэн хөрөнгийн ашиглалтай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй, тооцоо судалгааг хийгээгүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 2.2.4⁷ заалтыг хэрэгжүүлээгүй, орон нутгийн төсөвт нэмэлт ачаалал үүсгэх, шаардлагагүй хөрөнгө бий болох зэрэг үр дагавартай байна.

Иймд хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн, цаашид гарах үр дагаврыг цогцоор нь тооцож судлан үр ашигтай төсөл, арга хэмжээг төлөвлөж байх нь зүйтэй.

2.3 Бүлэг Б. Аудитын дүн:

Б. Гол асуулт / аудитын дэд зорилт 2: Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

- **Хариулт:** Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарт заасан журмыг баримтлалгүй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 6 удаагийн тендерт шаардлага хангаагүй оролцогч шалгаруулсан байна.

Нийт 37 төсөл, арга хэмжээнд боловсруулсан тендерийн баримт бичгийн 5 хувь буюу 2 тендерийн баримт бичиг алдаатай боловсруулагдсан байна.

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр баталсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд 17,686.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,465.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 68 төсөл, арга хэмжээнд худалдан авалт зарлахаар тусгасан бол үлдсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөө батлаагүй зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгдсөн 73 төсөл арга хэмжээний 3 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны А/652 захирамжаар сумдын Засаг даргад эрх шилжүүлжээ. Үүнд:

- Эрдэнэдалай сумын Хонины нэхий элдэх, эсгий боловсруулах үйлдвэрийн барилгын дуусгал;
- Говь-Угтаал сумын төвийн гэрэлтүүлэг;
- Эрдэнэдалай сумын Спорт төвийн өргөтгөлийн барилгын дуусгал;

⁵ Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

⁶ Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

⁷ Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

Гэвч дээрх гурван ажил нь зураг төсөв, техник үзүүлэлт байхгүй шалтгаанаар холбогдох сумдын Засаг дарга нар худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Хүснэгт-3: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тендер зарлалын төрөл

ТАХ-ний ангилал	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Шууд худалдан авалт	Нийт
Барилга, байгууламж	22	5	6	33
Тоног төхөөрөмж	9	14	4	27
Их засвар	8	2	0	10
Нийт	39	21	10	70

Үүнээс 6,283.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагаа зарлагдсан болон зарлахаар бэлтгэж байсан боловч аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/1440 дугаар албан бичигт дурдсан цаг үеийн зайлшгүй шаардлагаар худалдан авах ажиллагааг зогсоосон байна. Харин 1,815.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээ зураг төсөв, техникийн тодорхойлолт байхгүйгээс худалдан авах ажиллагаа зохион байгуулах боломжгүй болсон байна.

Тайлант онд 37 төсөл, арга хэмжээнд боловсруулагдсан тендерийн баримт бичгийн 5 хувь буюу 2 тендерийн баримт бичгийг алдаатай боловсруулсан гэсэн үндэслэлээр гомдол ирж өөрчлөлт орсон бол 9 төсөл, арга хэмжээнд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.5⁸ дахь заалтыг үндэслэн тухайн үнэлгээний хороодын хуралдаанаар тендерийн баримт бичигт шаардсан шалгуур үзүүлэлтийг багасгах, тендерт оролцогчдыг нэмэгдүүлэх зорилготойгоор 13 удаагийн өөрчлөлт хийгдсэн байна.

Зарлагдсан 70 удаагийн тендерийн 27.1 хувь буюу 19 тендер оролцогчгүй, 24.3 хувь буюу 18 тендер оролцогчдын ирүүлсэн тендерийн баримт шаардлага хангаагүй тул амжилтгүй болж үлдсэн 48.6 хувь нь амжилттай болж гэрээ байгуулах эрх олгогджээ.

Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарт заасан журмыг баримтлалгүй 3 төсөл, арга хэмжээг шүүд худалдан авалтын аргаар, 1 төсөл хөтөлбөрийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар болон шүүд худалдан авалтын аргаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо 20.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий аймгийн ОНХО 3, сумын ОНХО 1 нийтдээ 4 бараа, төсөл хөтөлбөрийг Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ын⁹ баримтлахгүй худалдан авалт хийсэн байна. Үүнээс 1 төсөл, арга хэмжээний худалдан авалт хууль эрх зүйн үндэслэлтэй байсан бол бусад 3 төсөл, арга хэмжээний худалдан авалт нь хууль, журамд нийцээгүй байна.

Хүснэгт-4: ХАА-ны журам буруу сонгосон ТАХ-ний мэдээлэл

Баталсан этгээд	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Худалдан авалтын арга	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/
Аймгийн ИТХ	Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж	Тоног, төхөөрөмж	ШХА	25.0	25.0
	Универсал трактор /Дэлгэрхангай сум/	Тоног, төхөөрөмж	ШХА	90.0	89.0
	Үндэсний их баяр наадам арга хэмжээ	Төсөл хөтөлбөр	ХА, ШХА	200.0	199.3
Баянжаргалан сумын ИТХ	ТҮЦ машин	Тоног, төхөөрөмж	ШХА	25.0	20.0

Formatted Table

Тайланд онд үүссэн зудад мал ихээр хорогдсонтой холбоотойгоор малын гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлгэрхангай суманд малын сэг зэм зайлуулах ажилд универсал тракторын хэрэгцээ яаралтай шаардлагатай болсон тул ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 35 дугаар

⁸ Тендер шалгаруулалтад нэг ч тендер ирээгүй бол захиалагч тендер ирээгүй шалтгааныг судалж, худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулах эсэхийг шийдвэрлэнэ

⁹ 1. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-20.0, Ажил-20.0, Үйлчилгээ-20.0/;

2. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-100.0, Ажил-150.0, Үйлчилгээ-100.0/

зүйлийн 35.1.2¹⁰ дахь заалтыг үндэслэн шууд гэрээ байгуулжээ. Ингэхдээ ижил барааны тендерт шалгарч чанар стандарт хангасан техник нийлүүлсэн тухай тодорхойлолтой байгууллагатай 89.0 сая төгрөгийн гэрээг байгуулан худалдан авалтыг хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар тендер зарлахаар худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан боловч 25.0 сая төгрөгийн шууд худалдан авалтын аргаар гэрээ хийсэн байна.

Үндэсний их баяр наадам арга хэмжээ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын 100 жилийн ойд зориулагдан батлагдсан 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл хөтөлбөр байна. Тайлант оны эхэнд төсөвт өртгийн 20.0 сая төгрөгөөр биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сурталчлан таниулах зорилгоор брэнд боловруулах ажлын гэрээг шууд худалдан авалтын аргаар хийж үлдсэн 180.0 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрт нээлттэй тендер шалгаруулалтын аргыг ашиглах байсан боловч харьцуулалтын аргаар тендер зарласан байна. Энэ нь журамт тогтоосон баяр наадамд зарцуулах төсвийн хязгаарыг хэтрүүлсэн, батлагдсан төсөвт өртгийг хуваан зарцуулсан, худалдан авах ажиллагааны журам зөрчсөн үйлдэл байна.

Баянжаргалан сумын ТҮЦ машин нь сумын ОНХО-аар батлагдсан төсөл, арга хэмжээ бөгөөд 25.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан буюу харьцуулалтын аргаар худалдан авалтыг зохион байгуулах ёстой байсан боловч үндэслэлгүйгээр 20.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

Тайланд онд 8 төсөл, арга хэмжээнд 10 удаагийн гомдол ирж 8 гомдол нь оролцогчийн талд шийдвэрлэгдсэн байна.

Худалдан авах ажиллагаа зарласан 37 төсөл арга хэмжээний 34 төсөл арга хэмжээ нь амжилттай болж гэрээ байгуулсан бол 3 төсөл, арга хэмжээ амжилтгүй болсон байна.

Хүснэгт-5: Тендерийн дундаж болон гомдол гаргасан тоо, шийдвэрлэсэн хувь

ТАХ-ний тоо	Нийт тендер зарласан тоо	Нэг ТАХ-ний тендер зарласан дундаж тоо	Гомдол гарсан ТАХ-ний тоо	Гомдлын тоо	Гомдол хянасан байдал	
					Захиалагчийн талд	Гомдол гаргагчийн талд
37	70	1.9	8	10	20%	80%

Гомдол гарсан 8 төсөл, арга хэмжээний 2 төсөл, арга хэмжээнд ирсэн гомдлыг Сангийн яамнаас хянан захиалагчийн талд шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Эрдэнэдалай сумын Соёлын төвийн тоног төхөөрөмж худалдан авах.
- Аймгийн 18 ЕБС, 22 цэцэрлэгт аяга таваг угаагч, ариутгагч худалдан авах

Гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн 8 гомдлын 2 гомдол нь тендер зарласнаас нээх хугацааны хооронд буюу тендерийн оролцохыг хүсэгч байгууллагаас гаргасан гомдол бол бусад 6 гомдлыг Сангийн яамнаас хянан үзэж тендерт хамгийн сайн гэж үнэлэгдсэн байгууллага нь гомдлын дагуу шаардлага хангаагүй гэж үзэн захиалагчийн олгосон гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосон байна.

2.4 Бүлэг В. Аудитын дүн:

В. Гол асуулт / аудитын дэд зорилт 3: Хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан уу?

- **Хариулт:** Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, бий болсон хөрөнгийг хууль, журмын дагуу бүртгэлд тусгах ажил хангалтгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн байна.

¹⁰ Онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах яаралтай хэрэгцээ бий болсон шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй;

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57 төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч компаниудтай нийт 14,381.1 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Гэрээний дагуу 12,157.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоос 8,290.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 68.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт-6: Санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээлэл /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Тайлант онд санхүүжих	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Өмнөх оноос шилжсэн	426.3	414.8	399.4	323.6	81.0
2	Барилга, байгууламж	9,732.2	9,415.5	5,085.5	2,201.2	43.3
3	Тоног төхөөрөмж	1,946.9	1,822.3	1,946.9	1,724.5	88.6
4	Хөтөлбөр	3,210.1	1,141.6	3,210.1	2,593.6	80.8
5	Их засвар	1,694.9	1,586.8	1,515.1	1,447.6	95.5
	Дүн	14,950.4	14,381.1	12,157.0	8,290.4	68.2

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлд:

- Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт, Шүүхийн замыг төв замтай холбох авто зам шинээр барих ажлууд тайлант оны сүүлд гэрээ байгуулсан тул он дамжин хэрэгжих;
- Аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэл 40 хувьтай байгаа нь их нөлөө үзүүлжээ.

Чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцааг төсөл, арга хэмжээ бүрээр авч үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Гэрээний дүн нь 100.0 сая төгрөгөөс дээш дүнтэй Говь-Угтаал сумын нийтийн биеийн тамирын талбайн өргөтгөл, Дэлгэрхангай сумын дотуур байрны засвар, Луус сумын эмнэлгийн барилгын засвар, Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн цэвэр бохир усны засварын 4 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг болон гэрээнд заасны дагуу 32.1 сая төгрөгийн чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцааг байршуулаагүй;
- Боржигон мандал өрхийн эмнэлгийн гадна дулаан, цэвэр, бохирын ажил, аймгийн Засаг даргын Тамгын газрын дээврийн засвар, 4-р сургуулийг төв замтай холбох авто зам, Бизнес хөгжлийн төв орчмын авто зогсоол, тохижилтын ажил, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын барилгын заалнуудын засварын 4 ажлын чанарын баталгаат хугацааны барьцааг гэрээний үнийн дүнгийн 3 хувиар тооцож байршуулсан.

Цаашид ямар төсөл, арга хэмжээнд ажлын чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцааг хуулийнд заасан хувь, хэмжээгээр шаардах талаар анхаарч ажиллах нь зүйтэй.

Зураг төсөв, ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээ төлөвлөн баталснаас хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, төсвийн жилд багтаж хэрэгжихгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 40 дугаар тогтоолоор баталсан 86 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 67.4 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт-7: ТАХ-ний хэрэгжилт

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо	Гүйцэтгэл		
	Хэрэгжиж дууссан	Хэрэгжилт дутуу	Хэрэгжээгүй
86	50	8	28

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнээс тайлант хугацаанд хэрэгжилт дутуу 8 төсөл, арга хэмжээний 3 нь өмнөх оноос шилжсэн, 5 нь шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 32.5 хувь буюу 12,356.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 28 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байгаагаас 16 нь батлагдсан зураг, төсөвгүй, ТЭЗҮ /техникийн тодорхойлолт/-гүйгээс тендер шалгаруулалтыг зохион байгуулж чадаагүй байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс чанаргүй хийгдсэн, техникийн тодорхойлолтын шаардлагад нийцэхгүй машин, тоног төхөөрөмж хүлээж авсан, шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн зөрчил байсаар байна. Тухайлбал:

- Боловсрол, соёлын үйлчилгээнд дунд оврын автобус 224.9 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсан байна. Хүлээн авах комиссын гишүүн, Авто тээврийн газрын инженер “маш их элэгдэл, эвдрэлтэй” гэж дүгнэн нийт гишүүдийн 3 нь хүлээж авахаас татгалзсан байхад хүлээн авах шийдвэр гаргасан байна. Аймгийн биеийн тамир, спорт газарт хүлээлгэн өгсөн дунд оврын автобусыг газар дээр очиж үзэхэд дугуйнууд хээгүй, хуучирсан, толь хагарч замаскаар тогтоож янзалсан, копутны болон тээш агуулах савны түгжээ ажиллахгүй гараар онгойдог, запас дугуй байхгүй байсан.
- Сайнцагаан сумын багуудад ахмадын төв шинээр барих төсөл, арга хэмжээг жил бүр төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Тайлант онд 2 ахмадын төвийг 192.6 сая төгрөгөөр барьж Айраг багийнх баригдаж дууссан бол Арвижих багийнх дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Харин Өлзийт сумын ахмадын хороонд 22.9 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийг нийлүүлсэн боловч одоог хүртэл ахмадын хорооны байр нь жижиг, багтахгүй шалтгаанаар ашиглаагүй шинээрээ хадгалагдаж байна.
- “Үндэсний их баяр наадам арга хэмжээ” нэртэй төсөл, арга хэмжээнд 200.0 сая төгрөг баталж Сайнцагаан сумын 100 жилийн ойн баяр наадмын арга хэмжээнд зарцуулсан байна.

Аймгийн Засаг дарга 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар захиалагчийн хяналт хийлгэхээр гэрээ байгуулж амжилттай ажилласан байна.

Тайлант онд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас гэрээний дагуу Боржигон мандал өрхийн эмнэлгийн гадна дулаан, цэвэр, бохирын ажил, Мандалговь цэцэрлэгт хүрээлэнгийн Амралт зугаалгын бүсийн тохижилтын ажил, 4-р сургуулийг төв замтай холбох авто зам, Бизнес хөгжлийн төв орчмын авто зогсоол, тохижилтын ажил, Дэлгэрхангай сумын дотуур байрны засвар зэрэг 14 барилга, байгууламж, засвар, тохижилтын ажилд давхардсан тоогоор 20 удаагийн захиалагчийн хяналтыг хийж, тайлан, фото зургаар баримтжуулсан байна.

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу бүртгэлд тусгахгүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнээс 14,205.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, комисс хүлээн авсан байна.

Аудитын явцад хөрөнгөд бүртгэж авсан байдлыг түүвэрлэн үзэхэд 761.9 сая төгрөгийн өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгүүдийг орон нутгийн өмчид бүртгээгүй байна. Мөн 38.1 сая төгрөгийн өртөгтэй Луус сумын төрийн албан хаагчдын байрны пасадны засвар, 63.7 сая төгрөгийн өртөгтэй Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын дээврийн засвар ажлыг үндсэн хөрөнгийн дансанд нэмж капиталжуулж бүртгээгүй байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж болон хөрөнгө оруулалт хариуцсан нэгж, ашиглагч байгууллагын хамтран ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг комисс хүлээн авсан даруйд хөрөнгийн бүртгэл бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж байх шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 17.0 хувь буюу 3,810.1 сая төгрөгийг төсөл хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн нь өмнөх оноос 2,627.3 сая төгрөг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.
2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр, сүү хөтөлбөр, тэмцээн уралдаан, наадам зохион байгуулах зэрэг хөрөнгийн бус нэг удаагийн шинж чанартай арга, хэмжээнүүдэд баталсан байна.
3. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 698.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ нь "Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл"-тэй, 553.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ нь "Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй тус тус уялдаагүй байна.
4. Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэх боломжгүй "Дашигшилэн хийдийн барилгын дотор завсар", "Нийтийн эзэмшлийн орон сууцуудын давхар дундын цахилгааны шийт солих", "Гэр" төсөл, Мандалговь хотын сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх байр зэрэг 630.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг баталсан байна.
5. Сайнцагаан сумын Айраг, Арвижих багуудад ахмадын төв шинээр барих, Олгойн говийн ус цэвэршүүлэх байгууламжийн барилга шинээр барих, Дэлгэрхангай сумын 4 дүгээр багийн төвийн барилга шинээр барих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө үндсэн хөрөнгийн ашиглалтай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй, тооцоо судалгааг хийгээгүй байна.
6. Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр баталсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд 17,686.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,465.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 68 төсөл, арга хэмжээнд худалдан авалт зарлахаар тусгасан бол үлдсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөө батлаагүй зохион байгуулсан байна.
7. Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарт заасан журмыг баримтлалгүй 3 төсөл, арга хэмжээг иүүд худалдан авалтын аргаар, 1 төсөл хөтөлбөрийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.
8. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга, байгууламжийн 33 төсөл, арга хэмжээний 87.9 хувь нь зураг, төсөвтэйгөөс 9 нь Барилга хөгжлийн төвийн ерөнхий магадлалын дүгнэлттэй байна. Тоног төхөөрөмжийн 27 төсөл, арга хэмжээнээс 25 буюу 92.6 хувь нь ТЭЗҮ /Техникийн тодорхойлолт/-ийг боловсруулж захиалагчаар батлуулсан бол 2 нь ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээ байна.
9. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон ч бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байна.
10. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57 төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч компаниудтай нийт 14,381.1 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үүнээс 12,157.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээс 8,290.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 68.2 хувийн гүйцэтгэлтэй байна.
11. Хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг болон гэрээнд заасны дагуу 32.1 сая төгрөгийн чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгирүүлэх хугацааны барьцааг байршуулаагүй.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Шинээр баригдах барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө үндсэн хөрөнгийн ашиглалтай холбоотой урсгал зардал, төсөвт нөлөөлөх ачааллын талаар тооцоо судалгааг хийж эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцон төлөвлөж хэрэгжүүлэх;
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэх боломжтой төсөл арга хэмжээг төлөвлөх;
3. Төсвийн тухай хууль болон холбогдох журмын шаардлагад нийцсэн батлагдсан зураг төсөвтэй, ТЭЗҮ, техникийн тодорхойлолттой төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлэх;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn